

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.100.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага	MNS 5105:202х
Occupational safety and health. Occupational hygiene. Hygiene protection areas norm, general requirements	MNS 5105:2001- ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэ стандартаар үйлдвэрлэлийн технологи үйл ажиллагаанаас үүссэн хортой эрсдэлт хүчин зүйлийг гадаад орчинд тархахаас урьдчилан сэргийлэх, аж ахуйн нэгжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлагыг тогтооно.

2. Норматив эшлэл

Энэ стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

БН 6-Д 30-02-07 “Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө”

БН 6-Д 30-01-04 “Хот, тосгоны барилгажилтын төлөвлөлтийн норм ба дүрэм”

MNS 4967, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Нэр томъёо, тодорхойлолт”

3. Нэр томъёо, тодорхойлолт

3.1

Эрүүл ахуйн хамгаалалтын бүс

Гадна орчинд үйлдвэрлэлийн хортой нөлөө бүхий технологи ажиллагаатай аж ахуйн нэгжийн хүн, мал амьтан, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх аюулын хязгаарын хүрээ

3.2

Тэсэрч дэлбэрэх аюулын бүс

Тэсэрч дэлбэрэх аюул тархах хүрээ

3.3**Галын аюулын бүс**

Галын аюул тархах хүрээ

3.4**Химийн аюулын бүс**

Химийн хорт бодисын ууршилтын тархах хүрээ

3.5**Биологийн аюулын бүс**

Амьтан, ургамлын гаралтай өвчин үүсгэгч нян, нянгийн өсгөвөр, эм бэлдмэлийн нөлөөлөл тархах хүрээ

3.6**Цацрагийн аюулын бүс**

Цацрагийн нөлөөлөл тархах хүрээ

4. Ангилал**4.1**

Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хүн, мал амьтан, байгаль орчинд нөлөөлж болзошгүй аюулын хүрээгээр нь дараах байдлаар ангилна. Үүнд:

4.1.1 Галын

4.1.2 Тэсэрч дэлбэрэх

4.1.3 Химийн

4.1.4 Биологийн

4.1.5 Цацрагийн

5. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн ерөнхий шаардлага**5.1**

Орчиндоо эрсдэл бүхий хүчин зүйл үүсгэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага нь эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоохдоо энэ стандартад заасан ангилал, бүсийн зөвшөөрөх дээд хэмжээг баримтална.

5.2

Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага нэг бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж болох бөгөөд технологи, тоног төхөөрөмж, түүхий эд материал, бодис, бүтээгдэхүүн нь стандартад заасан шаардлагаас их дуу шуугиан, доргион, цахилгаан соронзон орон үүсгэхгүй, химийн болон цацраг идэвхт бодисыг ялгаруулахгүй, ажилтны эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байна.

5.3

Аж ахуйн нэгж, байгууллагад хэд хэдэн сөрөг нөлөөлөл хамсан үйлчилж байвал

хамгийн их эрсдэлтэй хүчин зүйлээр тооцож эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг тогтооно.

5.4

Эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд дараах байгууламжууд байрлаж болно

- Аж ахуйн нэгж, байгууллагын туслах цех тасаг, барилга байгууламж, хауулын байр, машины зогсоол, цахилгаан дамжуулах агаарын шугам, ус хангамжийн гүний худаг, ус хангамж, дулаан, бохир усны гадна шугам сүлжээ, ус түгээгүүр ба бохир усны насосын станц, усыг эргүүлэн ашиглах байгууламж, газрын доорх нөөшлөх савнууд /резервуар/ нефть хийн хоолойнууд
- Галын пост, халуун ус, гараж, агуулах, захиргаа, зохион бүтээх товчоо, үйлдвэр-сургалтын байр, цайны газар, угаалгын газар, үйлдвэрийн цехийн эмнэлэг, эрдэм шинжилгээний лаборатори

6. Хориглох зүйл

6.1

Хими, физик, биологийн хүчин зүйлс нь харилцан үйлчилснээс аюул, эрсдэлийн нөлөөллийг нэмэгдүүлэх (дэмжих) аж ахуйн нэгж, байгууллага нэг бүсэд үйл ажиллагаа явуулах

6.2

Нэг үйлдвэрээс ялгаран гарах сөрөг нөлөөлөл нь нөгөө үйлдвэрийн ажилтны эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх болон бэлэн бүтээгдэхүүн тоног төхөөрөмж, эд материалд муугаар нөлөөлөх үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагыг эрүүл ахуйн хамгаалалтын нэг бүсэд байрлуулах.

6.3

Спортын байгууламж, хүүхдийн байгууллага, сургууль цэцэрлэг, эмнэлэг, орон сууцны барилга байгууламжийг эрүүл ахуйн, хамгаалалтын бүсэд байрлуулах.

7. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ

7.1

Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээг гадаад орчинд үйлдвэрлэлийн хортой нөлөө бүхий технологитой аж ахуйн нэгжийн хүчин чадал, технологийн онцлог нөхцөл, орчиндоо ялгаруулж байгаа хортой ба эвгүй үнэртэй бодис, дуу шуугиан, доргион, радио давтамжийн цахилгаан соронзон долгион, хэт нам дуу болон бусад хүчин зүйлийн хэмжээ, шинж чанар, тэдгээрийн орчиндоо үзүүлэх нөлөөллийг үндэслэн тогтооно.

7.2

Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ нь хүснэгт 1-т заасны дагуу байна.

Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ

Аж ахуйн нэгж, байгууллагын эрүүл ахуйн хамгаалалтын бүс	Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ, /м-ээр /
1-р	1000
2-р	500
3-р	300
4-р	100
5-р	50

7.3

Эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд хамаарах аж ахуйн нэгж, байгууллагын нэрийн жагсаалтыг А,В,С,D,E хавсралтад үзүүлэв.

8. Ариутгах татуургын цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

8.1

Ариутгах татуургын цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээг цэвэрлэх байгууламжийн хүчин чадалд үндэслэн тогтооно.

8.2

Ариутгах татуургын цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ нь хүснэгт 2-т заасны дагуу байна.

Хүснэгт 2

Ариутгах татуургын цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ

Бохир усны цэвэрлэх байгууламж	Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ, м			
	Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал 1000 м³, хоног			
	0.2 хүртэл	0.2-5.0	5.0-50.0	50.0-280.0
1. Лагийн талбайтай биологийн Бамеханик цэвэрлэх байгууламж	150	200	400	500
2. Лагийг халааж боловсруулах цэгтэй биологийн бамеханик цэвэрлэх байгууламж, талбай	100	150	300	400
А. Шүүх талбай	200	300	500	1000
Б. Услах талбай	150	200	400	1000
В. Биологийн цөөрөм	200	200	-	-

9. Тэсэрч дэлбэрэх аюулын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ

9.1

Тэсэрч дэлбэрэх аюулын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээг цэнэгийн тэсрэлтийн үйлчлэлийн үзүүлэлт, хамгийн бага эсэргүүцлийн шугамын хэмжээнээс хамааруулан тогтооно.

9.2

Тэсэрч дэлбэрэх аюулын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ нь хүснэгт 3-т заасны дагуу байна.

Тэсэрч дэлбэрэх аюулын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ

Хамгийн бага эсэргүүцлийн шугам , W	Цэнэгийн тэсрэлтийн үйлчлэлийн үзүүлэлтээс (n) хамаарах аюулын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ, м			
	n -1.0	n -1.5	n -2.0	n -2.5-3.0
1.5	100	150	250	300
2.0	100	200	350	400
4.0	150	250	500	550
6.0	150	300	550	650
8.0	200	300	600	700
10.0	250	400	600	700
12.0	250	400	700	800
15.0	300	400	700	800
20.0	350	400	800	1000
25.0	400	500	1000	1000
30.0	400	500	1000	1200

10. Нефть бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцуудын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг MNS 4628 стандартад зааснаар тогтооно.

ТӨГСӨВ

А хавсралт
(Мэдээллийн)
1-р бүс

**Эрүүл ахуйн хамгаалалтын бүс нь 1000 м-т хамаарах аж ахуйн нэгж,
байгууллага**

А.1 Химийн бүтээгдэхүүний үйлдвэр

- A.1.1 Их концентрацитай эрдэс бордооны үйлдвэр
- A.1.2 Нефтийн хийг цагт 5000 м³-аас илүү хэмжээгээр гаргадаг үйлдвэр
- A.1.3 Хиймэл торгонцор утас ба эслэг цаас хийдэг үйлдвэр
- A.1.4 Сульфат ба сульфат циллюлиозоор цаас хийдэг үйлдвэр
- A.1.5 0,5% / жингээр / хувиас дээш хүхэрт нефть боловсруулах үйлдвэр
- A.1.6 Чулуун нүүрс боловсруулах үйлдвэр
- A.1.7 Металл занар боловсруулах үйлдвэр
- A.1.8 Мөнгөн усны үйлдвэр
- A.1.9 Хүхрийн хүчил ба хүхэрлэг хийн үйлдвэр
- A.1.10 Хүхэрт нүүрс устөрөгчийн үйлдвэр
- A.1.11 Давсны хүчлийн үйлдвэр
- A.1.12 Азотын бордоо хийх үйлдвэр
- A.1.13 Фосфорын үйлдвэр /улаан фосфор/
- A.1.14 Хлорын үйлдвэр
- A.1.15 Хүхэрлэг органик будагт бодисын үйлдвэр
- A.1.16 Хиймэл каучукийн үйлдвэр
- A.1.17 Хлоржуулах аргаар ховор металл, төмөрлөг гаргах үйлдвэр
- A.1.18 Органик уусгагч ба тосны үйлдвэр / бензол, толуол, ксилол, нафталан, фенол, крезол, антрацен, акирицин, фенотрен, карбозол /
- A.1.19 Хөөний үйлдвэр
- A.1.20 Урвалжуудын үйлдвэр
- A.1.21 Этилийн үйлдвэр
- A.1.22 Эмийн бодисын болон бэлдмэлүүдийг химийн синтезийн аргаар үйлдвэрлэх үйлдвэр

А.2 Төмөрлөгийн үйлдвэр

- A.2.1 Жилд 3000 тонноос дээш өнгөт төмөрлөгийг дахин боловсруулдаг үйлдвэр
- A.2.2 1500 м³- ээс илүү багтаамж бүхий зуухтай ширэм хайлдаг үйлдвэр
- A.2.3 Өнгөт төмөрлөгийг хар цагаан тугалга, зэс, никель цэвэрлэсэн ба ердийн хүдрээс шууд хайлж авах үйлдвэр
- A.2.4 Хайлуулсан хөнгөн цагааны давснаас /нааги шороо/ цахилгаан задлангийн аргаар хөнгөн цагаан гаргах үйлдвэр
- A.2.5 Жилдээ 100000 тонноос дээш өнгөт цутгамал үйлдвэрлэх үйлдвэр

A.3 Хүдэр ба төмрийн хүдэр олборлох үйлдвэр

A.3.1 Хоногт 0,5 тонн хүхэрлэгтэй нефтийг гаргах үйлдвэр

A.3.2 Марганц, хүнцэл, мөнгөн ус, хар тугалгыг олборлох үйлдвэр

A.3.3 Байгалийн хийг олборлох үйлдвэр

A.4 Барилгын материалын үйлдвэр

A.4.1 Портланд цементийн шаарга ба пуццеланы цементийг жилд 150000 тонноос илүү хэмжээгээр гаргах үйлдвэр

A.4.2 Шохой, цемент шамотыг эргэлтийн зууханд шатаах аргаар гаргаж авах үйлдвэр

A.5 Мод боловсруулах үйлдвэр

A.5.1 Модыг химийн аргаар бэхжүүлэх ба модны нүүрс гаргах үйлдвэр

A.6 Нийгэм, ахуйн үйлчилгээний байгууламжууд

A.6.1 Хог боловсруулах, хог шатаах төвлөрсөн газар

A.6.2 Хатуу хог хаягдлыг цуглуулах тохижуулсан газар, талбай

A.6.3 Малын сэг булах газар

A.6.4 Ахуйн хатуу хог хаягдлын далан байгуулах талбай

A.7 Эрчим хүчний үйлдвэр

A.7.1 Дулааны цахилгаан станц

**В хавсралт
(Мэдээллийн)
2-р бүс**

Эрүүл ахуйн хамгаалалтын бүс нь 500 м-т хамаарах аж ахуйн нэгж,
байгууллага

В.1 Химийн бүтээгдэхүүний үйлдвэр

В.1.1 Шүвтэрийн үйлдвэр

В.1.2 Нефтийн байгалийн хий боловсруулах үйлдвэр

В.1.3 Нүүрс ба хүдэр хэрэглэж цагт 25000-50000 м³ генераторын хий гаргадаг үйлдвэр

В.1.4 Давирхай, түүний шаарыг боловсруулах үйлдвэр

В.1.5 Эфирын үйлдвэр

В.1.6 Эфирийг ашиглаж хуванцар хийдэг үйлдвэр

В.1.7 Хүхэрт устөрөгчийг ашиглан хлорлог бари гаргадаг үйлдвэр

В.1.8 Цууны хүчлийн үйлдвэр

В.1.9 0,5 хувиас бага хүхэрт нефть боловсруулах үйлдвэр

В.1.10 Дэгдэмтгий органик уусгагчийг хэрэглэж хиймэл арьс хийдэг үйлдвэр

В.1.11 Органик нийлэг үйлдэхүүнд /спирт, этилийн спирт гэх мэт/, цагт 5000 м³-ээс их нефтийн хий боловсруулах үйлдвэр

В.1.12 Шөрмөсөн чулуун эзлэхүүний үйлдвэр

В.2 Төмөрлөгийн үйлдвэр

В.2.1 Магнийн үйлдвэр

В.2.2 Жилд 2000-3000 тонн өнгөт металл гаргадаг үйлдвэр

В.2.3 Жилдээ 2000-3000 тонн өнгөт металл дахин боловсруулдаг үйлдвэр /зэсийн хүдэр баяжуулах/

В.2.4 Хайлуур жоншны үйлдвэр

В.2.5 500-1500 м³ багтаамж бүхий зуухтай ширэм хайлуулдаг үйлдвэр

В.2.6 Тугалган аккумуляторын үйлдвэр

В.3 Хүдэр ба төмрийн хүдэр олборлох үйлдвэр

В.3.1 Металл занар олборлох үйлдвэр

В.3.2 Чулуун нүүрс, тэс нүүрс, хүрэн нүүрс олборлох үйлдвэр

В.3.3 Фосфор апатиттай чулуу болон колчеданийг химийн арга хэрэглэхгүйгээр олборлох үйлдвэр

В.3.4 Төмөр ба олон металлуудыг олборлох ба ил задгай боловсруулах үйлдвэр

В.4 Барилгын материалын үйлдвэр

В.4.1 Портланд цемент, шааргыг жилд 5000-150000 тонн хүртэл хэмжээгээр гаргадаг үйлдвэр

В.4.2 Гөлтгөний үйлдвэр

В.4.3 Барилгын хүдрийн бус материал /элс, хайрга г.м/-ын үйлдвэр

В.4.4 Шохойн үйлдвэр

В.4.5 Асбест бетоны үйлдвэр

В.5 Мод боловсруулах үйлдвэр

В.5.1 Модны нүүрсийг реторын аргаар боловсруулах үйлдвэр

В.6 Түүхий эд боловсруулах үйлдвэр

В.6.1 Нэхмэлд химийн бодис шингээж боловсруулалт хийх үйлдвэр

В.6.2 Бүс барааг цайлгах, будах үйлдвэр

В.7 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр

В.7.1 1000-аас дээш толгой малтай аж ахуйн нэгж

В.7.2 Мал нядлах газар

В.7.3 Өлөн гэдэс угаах үйлдвэр

В.7.4 Мал ачсан тээврийн хэрэгслийг угааж цэвэрлэх, ариутгах өртөө салбарууд

В.8 Холбооны байгууллага

В.8.1 Радио реле, телевизийн нэвтрүүлэх, дамжуулах байгууламж

С хавсралт
(Мэдээллийн)
3-р бүс

Эрүүл ахуйн хамгаалалтын бүс нь 300м-т хамаарах аж ахуйн нэгж,
байгууллага

С.1 Химийн бүтээгдэхүүний үйлдвэр

- С.1.1 Чулуун нүүрсний нэрмэл давирхай ба нефть, шилмүүсний нэрэлтээс үлдсэн шаараар битум ба бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр
- С.1.2 Эрдэс давсны үйлдвэр
- С.1.3 Цагт 1000-5000 м³ нефтийн хий, 5000-25000 м³ үүсгүүрийн хий гаргах үйлдвэр
- С.1.4 Хуванцрынх үйлдвэр /карболит, хлорванил г.м/
- С.1.5 Маажингийн үйлдвэр
- С.1.6 Резин ба резинэн гутлын үйлдвэр
- С.1.7 Сурьма, висмут, литийн давсыг ашиглан төмөрлөгийн хүдрийг химийн аргаар боловсруулах үйлдвэр
- С.1.8 Этилийн спиртээр хиймэл каучук хийх үйлдвэр
- С.1.9 Хиймэл эрдэс будгийн үйлдвэр
- С.1.10 Лакийн үйлдвэр

С.2 Төмөрлөгийн үйлдвэр

- С.2.1 Резин буюу тугалган тусгаарлагчтай кабель утасны үйлдвэр
- С.1.2 Металл электродын үйлдвэр
- С.1.3 Жилд 100-2000 тонн өнгөт металл гаргадаг үйлдвэр
- С.1.4 500 м³—ээс бага багтаамжтай зууханд төмөр хайлуулдаг үйлдвэр

С.3 Хүдэр ба төмрийн хүдэр олборлох үйлдвэр

- С.3.1 0,5 хувиас /жингээр/ бага хүхрийн нэгдэл бүхий нефть гаргах үйлдвэр
- С.3.2 Чийгтэй аргаар баяжуулалт хийх үйлдвэр
- С.3.3 Төмөрлөг ба төмөрлөг бус хүдрийг ил уурхайн аргаар олборлох үйлдвэр
- С.3.4 Нунтаг нүүрс ба хүдрээр шахмал түлш хийх үйлдвэр

С.4 Барилгын материалын үйлдвэр

- С.4.1 Жилд 5000 тонн хүртэл цемент /глинит цемент, роман цемент, гөлтгөнөт шаарга г.м/ гаргах үйлдвэр
- С.4.2 Асфальт бетон, давирхайтай хар цаасны үйлдвэр
- С.4.3 Шилэн хөвөн ба ноосны шавдасны үйлдвэр
- С.4.4 Керамзитын үйлдвэр

С.5 Мод боловсруулах үйлдвэр

- С.5.1 Модонд химийн бодис шингээж бэхжүүлэх үйлдвэр
- С.5.2 Холтсоор хавтан бүрхүүл хийх үйлдвэр

С.6 Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр

- С.6.1 Бүх төрлийн арьс, шир боловсруулах анхан шатны үйлдвэрүүд
- С.6.2 Ноос, ноолуур угаах, боловсруулах үйлдвэр
- С.6.3 Жилд 300 тонн хүртэл техникийн тос боловсруулах үйлдвэр
- С.6.4 Боловсрогдоогүй ба давсалсан нойтон арьс / 200 ширхгээс илүү/ агуулах газар

С.7 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр

- С.7.1 1000 хүртэл толгой малтай аж ахуйн нэгж
- С.7.2 Шувуу жижиг амьтдын нядалгааны газар
- С.7.3 Загасны үйлдвэр
- С.7.4 Чихрийн манжингийн үйлдвэр
- С.7.5 Тэжээлийн антибиотикийн үйлдвэр

С.8 Нийгэм, ахуйн үйлчилгээний байгууламж

- С.8.1 Оршуулгын газар
- С.8.2 Хатуу хог хаягдлыг бордоонд ашиглах зорилгоор ариутган цэвэрлэдэг газар
- С.8.3 Бохир ус, хог тээвэрлэх машины хэсгийн парк, гараж
- С.8.4 Түүхий хаягдлын үндсэн агуулах
- С.8.3 Биотермийн камер

D хавсралт
(мэдээллийн)
4-р бүс

Эрүүл ахуйн хамгаалалтын бүс нь 100 м-т хамаарах аж ахуйн нэгж,
байгууллага

D.1 Химийн бүтээгдэхүүний үйлдвэр

- D.1.1 Бэлэн эслэг ба модоор цаас хийдэг үйлдвэр
- D.1.2 Глицерины үйлдвэр
- D.1.3 Нүүрс хүдэр хэрэглэж цагт 5000 м³ хүртэл генераторын хий үйлдвэрлэдэг үйлдвэр
- D.1.4 Шүвтэр ба ацетатын аргаар хиймэл утас хийдэг үйлдвэр
- D.1.5 Харандааны үйлдвэр
- D.1.6 Жилдээ 2000 тн-оос дээш саван үйлдвэрлэх үйлдвэр
- D.1.7 Чүдэнзний үйлдвэр
- D.1.8 Молибден, вольфром, кобалтын давснуудыг гаргаж авахын тулд ховор төмөрлөгийн хүдрүүдийг химийн аргаар боловсруулах үйлдвэр
- D.1.9 Давс буталж чанах үйлдвэр
- D.1.10 Калийн давсны хлорлог хүхрийн хүчлийн поташийн үйлдвэр
- D.1.11 Сахрын ба ванилийн үйлдвэр
- D.1.12 Цагт 1000 м³ хүртэл нефтийн хий гаргадаг үйлдвэр
- D.1.13 Органик уусгагч хэрэглэхгүйгээр гутлын резин үйлдвэрлэх үйлдвэр
- D.1.14 Эрдсийн будгаар цэрд шар, улаан зос хийх үйлдвэр
- D.1.15 Антибиотекийг биологийн аргаар гаргах үйлдвэр
- D.1.16 Поливинил хлорид болон бусад органик уусгагчийг хэрэглэхгүйгээр хиймэл арьс хийх үйлдвэр
- D.1.17 Парфюмерийн үйлдвэр
- D.1.18 Нунтаг шингэн угаагч бодисын үйлдвэр

D.2 Төмөрлөгийн үйлдвэр

- D.2.1 Тусгаарлагчтай кабель утасны үйлдвэр
- D.2.2 Халаалтын ба уурын тогооны үйлдвэр
- D.2.3 Жилдээ 10000 тонн ширэм ган, 100 тонн өнгөт төмөрлөг боловсруулдаг
Үйлдвэр

D.3 Хүдэр ба төмрийн хүдэр олборлох үйлдвэр

- D.3.1 Хар тугалга, хүнцэл ба хүдрээс бусад төмөрлөг ба төмөрлөг бус уурхайн аргаар олборлох үйлдвэр
- D.3.2 Хүдрийг өрөмдөх аргаар олборлох үйлдвэр
- D.3.3 Молор давс /хоолны/ олборлох үйлдвэр

D.4 Барилгын материалын үйлдвэр

- D.4.1 Шифер ба шөрмөсөн чулууны үйлдвэр
- D.4.2 Хиймэл чулуу ба бетон эдлэлийн үйлдвэр (байнгын бус ажилтай)
- D.4.3 Цахиурын ба улаан тоосгоны үйлдвэр
- D.4.4 Ваар болон галд тэсвэртэй эдлэлийн түүхий эд бэлтгэх үйлдвэр
- D.4.5 Шилний үйлдвэр
- D.4.6 Цахилгаан станцаас гарч байгаа хаягдлаар барилгын материал хийх үйлдвэр
- D.4.7 Цемент ба барилгын бусад тоосорхог материалыг агуулах байр
- D.4.8 Чулуу хайлах үйлдвэр
- D.4.9 Барилгын полимер материалын үйлдвэр

D.5 Модны үйлдвэр

- D.5.1 Мод хөрөөдөх , нэг загварын байшингийн болон сарампайн үйлдвэр
- D.5.2 Мод холтослох үйлдвэр
- D.5.3 Ислэг хавтангийн үйлдвэр

D.6 Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэр

- D.6.1 Хоолны үлдэгдэл хаягдлаар амьтны тэжээл хийдэг үйлдвэр
- D.6.2 Эсгий ба эсгий гутлын үйлдвэр
- D.6.3 Хиймэл арьсны үйлдвэр
- D.6.4 Үс хялгас, ноолуур, өд, эвэр ба туурай боловсруулдаг үйлдвэр

D.7 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр

- D.7.1 Альбумины үйлдвэр
- D.7.2 Спиртийн үйлдвэр
- D.7.3 Гурилын үйлдвэр
- D.7.4 Бяслагийн үйлдвэр
- D.7.5 Хүнсний ногоо хатаах, давслах, дарах зэргээр боловсруулалт хийх үйлдвэр
- D.7.6 Загас, консервын үйлдвэр
- D.7.7 Ургамлын тос боловсруулдаг үйлдвэр
- D.7.8 Эрдэнэ шиш, цардуулын үйлдвэр
- D.7.9 Мах боловсруулах үйлдвэр

D.8 Нийгэм, ахуйн үйлчилгээний байгууламж

- D.8.1 Дүүргийн түүхий эдийн бааз, захууд
- D.8.2 Автомашиныг цэвэрлэх механикжсан парк
- D.8.3 Хаягдлыг боловсруулалт хийлгүйгээр түр хадгалах агуулах
- D.8.4 Авто машины засвар- үйлчилгээний газар

Е хавсралт
(мэдээллийн)
5-р бүс

Эрүүл ахуйн хамгаалалтын бүс нь 50 м-т хамаарагдах аж ахуйн нэгж,
байгууллага

Е.1 Химийн бүтээгдэхүүний үйлдвэр

- Е.1.1 Хлорын цехгүй органик бус урвалжийн үйлдвэр
- Е.1.2 Жилд 2000 тонн хүртэл саван үйлдвэрлэх үйлдвэр
- Е.1.3 Хагас боловсруулагдсан үйлдэхүүнээр цаас, картон хийх үйлдвэр
- Е.1.4 Хуванцар эдлэлийн механик боловсруулалттай үйлдвэр
- Е.1.5 Фото химийн /фото хальс, фото цаас/ үйлдвэр
- Е.1.6 Цистерн угаах, цэвэрлэх, уураар утах газар
- Е.1.7 Устөрөгч ба хүчилтөрөгчийг шахаж савалдаг үйлдвэр
- Е.1.8 Эмийн бэлдмэлийн үйлдвэр

Е.2 Төмөрлөгийн үйлдвэр

- Е.2.1 Төмөрлөгийг цутгалгүйгээр илчээр боловсруулах, хатуу хайлшийг гаргаж авах үйлдвэр
- Е.2.2 Шүлтийн аккумуляторын үйлдвэр
- Е.2.3 Хүдрийг химийн аргаар боловсруулах цехгүй, хатуу хайлшийг гаргаж авах үйлдвэр

Е.3 Барилгын материалын үйлдвэр

- Е.3.1 Чулууг гаргаж авах, байгалийн чулууг боловсруулах үйлдвэр
- Е.3.2 Гөлтгөнөн эдлэлийн үйлдвэр
- Е.3.3 Шаазан эдлэлийн үйлдвэр

Е.4 Мод боловсруулах үйлдвэр

- Е.4.1 Хайрцаг ба тавилгын үйлдвэр
- Е.4.2 Модонд давс, усан уусмалын /хүнцлийн давсгүй/ түрхэж бэхжүүлэх үйлдвэр

Е.5 Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр

- Е.5.1 Гутлын үйлдвэр
- Е.5.2 Үс хялгасаар сойз, шүүр хийдэг үйлдвэр
- Е.5.3 Элдсэн арьсаар бүтээгдэхүүн хийдэг үйлдвэр
- Е.5.4 Эсгий засварын газар
- Е.5.5 Давсалсан нойтон арьсыг /200 ширхэг хүртэл хэмжээгээр/ түр хурааж хадгалдаг агуулах
- Е.5.6 Хивсний ба хиймэл каракулын үйлдвэр

Е.6 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр

- Е.6.1 Пивоны үйлдвэр / хөрөнгө бэлтгэх, арвайг соёолуулах, чанах г.м/
- Е.6.2 Чихэр, боовны үйлдвэр

- Е.6.3 Ногооны зоорь
- Е.6.4 Гоймонгийн үйлдвэр
- Е.6.5 Загас утах үйлдвэр
- Е.6.6 Сүү, тосны үйлдвэр
- Е.6.7 Хиамны үйлдвэр
- Е.6.8 Талхны үйлдвэр
- Е.6.9 Хүнсний хагас боловсруулагдсан бүтээгдэхүүнийг бэлтгэдэг үйлдвэр
- Е.6.10 Хоолны цууны үйлдвэр
- Е.6.11 600 тонноос илүү багтаамжтай зоорь
- Е.6.12 Ундааны үйлдвэр

Е.7 Бусад

- Е.7.1 Хөнгөн тэрэгний үйлчилгээний газар
- Е.7.2 Оёдол, сүлжмэлийн үйлдвэр
- Е.7.3 Хэвлэлийн үйлдвэр
- Е.7.4 Хими цэвэрлэгээний газар
- Е.7.5 Авто гараж